



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

20 10 оны 01 сарын 17 өдөр

Улаанбаатар хот

Хурал болсон газар: Шангри-Ла зочид буудал, 1 давхар, Нью-Йорк хурлын танхимд

Хурал болсон он, сар, өдөр: 2020 оны 1 дүгээр сарын 17-ны Баасан гараг

Хурал болсон цаг: 11 цаг 00 минут

Хурлын дарга: Мягмар овогтой Мөнхбаатар

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Хурлын ирц: 84.74 хувь

Хуралд биечлэн болон урьдчилан саналын хуудсаар оролцогчид:

№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Энгийн хувьцааны тоо ширхэг	Ирц
1	Б.Баттулга	1	0.00001%
2	Д.Адьяахүү	1	0.00001%
3	Д.Янжмаа	2	0.00001%
4	Б.Мөнхтулга	1	0.00001%
5	О.Гарамханд	2	0.00001%
6	Ж.Баатар	1	0.00001%
7	Ж.Энхтунгалаг	1	0.00001%
8	Б.Цэрэнжав	16	0.00011%
9	Д.Солонго	5	0.00003%
10	Г.Цолмонгэрэл	1	0.00001%
11	Б.Дүүрэнзаяа	5	0.00003%
12	Д.Батсайхан	1	0.00001%
13	Ц.Сүхбаатар	6	0.00004%
14	О.Ган-Эрдэнэ	1	0.00001%
15	BDSEC	2	0.00001%
16	Капитрон банк	210,631	1.41451%
17	"Ти Ди Би Капитал" ХХК	421,241	2.82887%
18	Монгол улсын хөгжлийн банк	210,621	1.41444%
19	"Ти Ди Би Капитал" ХХК	1,552,726	10.42743%
20	УБ Хотын банк	2,069,000	13.89450%
21	Азиа дайверсифайд рийл истэйт фонд нэг ХХК	2,610,412	17.53039%
22	Азиа дайверсифайд рийл истэйт фонд нэг ХХК	2,312,500	15.52974%
23	Монгол улсын хөгжлийн банк	3,081,955	20.69707%

★★★

Хуралд оролцсон албан тушаалтан:

1. Б.Гантулга, “МИК Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал;
2. Х.Батхишиг, Олон нийттэй харилцах хэлтсийн мэргэжилтэн;
3. Д.Гансүх, Мэдээлэл технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

М.Мөнхбаатар: “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хурлыг нээхтэй холбогдуулан тооллогын комисс ирцээ танилцуулна уу.

С.Амарсайхан: Сайн байцгаана уу? Та бүхэнд хурлын ирцийг танилцуулъя. “МИК Холдинг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд нийт 14,890,780 ширхэг нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс 12,469,132 буюу 84.74 хувийн ирцтэй байна.

М.Мөнхбаатар: Баярлалаа. Компанийн тухай хуулиар ирц хүрсэн байна. Мөн та бүхэнд шинэ оны мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн тогтоолыг уншиж танилцуулъя. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.2, 64.4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх хэсэг, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, 71.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3.4, 9 дүгээр зүйлийн 9.7.11, 9.7.12 дахь хэсгийг тус тус үндэслэн **тогтоох нь**: 1. “МИК Холдинг” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 11:00 цагт Шангри-Ла зочид буудал, 1 давхар, Парис-Бээжин хурлын танхим (Монгол улс, Улаанбаатар 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж-19)-д зохион байгуулж, хуралдуулахаар зарласугай. 2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөр тогтоосугай. 3. “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын мэдэгдэл”-ийг тогтоолын Хавсралт 1-р баталж, тус мэдэгдлийг хавсралт баримт бичгийн хамт 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөрт багтаан Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д тус тус хүргүүлсүгэй. 4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай зарыг Хавсралт 2-р баталж, 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр болон 12 дугаар 27-ны өдөр тус тус хоёроос доошгүй өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг Хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т даалгасугай. 5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 3-р баталж, энэхүү баримт бичгийг 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдэд тэдгээрт үйлчилж буй Үнэт цаасны компаниар дамжуулан хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж, танилцах бололцоогоор хангаж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т даалгасугай. 6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Мөнхбаатарыг томилсугай. 7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд: Комиссын дарга: Г.Саруул, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга; Гишүүн: Х.Маралмаа, ТУЗ-ийн ажлын албаны хуульч. 8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд: Комиссын дарга: С.Амарсайхан, “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн Эрсдэлийн удирдлагын газрын захирал; Гишүүн: Б.Булган, “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн Санхүү, төлөвлөлт шинжилгээний захирал; Гишүүн: Н.Энхмаа, “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн Хянан нийцүүлэлтийн газрын захирал; Гишүүн: Х.Маргад-Эрдэнэ, “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн Багцын удирдлагын хэлтсийн захирал; Гишүүн: Ж.Элбэгсайхан, “Монголын

Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн Захиргааны хэлтсийн ахлах мэргэжилтэн. 9.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг Хурлын дарга (М.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай. 10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг Хавсралт 4-р, санал авах хуудсыг Хавсралт 5-аар тус тус баталсугай. 11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын саналын хуудсыг Үнэт цаасны компаниар дамжуулан хүргүүлж, хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар өгөх санал авах ажлыг хурлын мэдэгдэл гаргаснаас эхлэн хурал эхлэх цаг хүртэл зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс (Г.Саруул)-т үүрэг болгосугай. 12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон гарах зардлын төсвийг Хавсралт 6-р баталж, батлагдсан төсвийн дагуу санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй. 13. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (М.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Мөнхбаатар. Энэ төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр хуралдаж байна. Өнөөдрийн хурлаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр, Улаанбаатар хот Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн тогтоох нь: 1. Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “...3 нь хараат бус...” гэсний дараа “..., 1 нь Монголбанкны төлөөлөл бүхий ердийн...” гэж нэмэлт, өөрчлөлт оруулсугай. 2. Энэ тогтоолын 1-т заасан дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж хянуулах, улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай. 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (М.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай. Үндсэндээ Монголбанк нь Монголын Ипотекийн корпорацийг ХХК байхаас эхлэн 1 төлөөллийг хэрэгжүүлдэг ердийн гишүүн ТУЗ-д байсан. Энэ дүрмийн өөрчлөлтийг оруулж Монголбанкнаас байнгын гишүүнтэй болгож байна. Үүний давуу тал нь 1 дүгээрт өнөөдрийн байдлаар нийт компанийн активын 80 гаруй хувийг 8 хувийг хөтөлбөрөөс хамаарч байгаа бөгөөд нийт 8 хувийн зээлийн эх үүсвэрийн 90 хувийг Монголбанк хэрэгжүүлдэг. Үүгээр дамжуулаад мөнгөний бодлого хэрэгжүүлдэг, Монголын Ипотекийн Корпорацийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл авах, бодлогын шинж чанартай оролцох гэсэн үүрэгтэйгээр ажилласан. Цаашдаа энэ үүргээ хэрэгжүүлэн төлөөлөн удирдах зөвлөлд байнгын гишүүнтэй байх нь зүйтэй гэсэн бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан. Хоёрдугаарт 2019 оны 1 дүгээр сарын сүүлээр 300 сая ам долларын бонд гаргасан бөгөөд онцлог нь Монгол улсын хувьд банкны бус салбараас анх удаа бие даан амжилттай гаргасан хэлцэл болсон. Монгол банк, Сангийн яам, Засгийн газар бодлогын дэмжлэг үзүүлсэн учраас энэ бондыг амжилттай гаргасан. Цаашид гадаадын хөрөнгө оруулагчийг татаж эх үүсвэрээ орон сууцны зах зээлд оруулахад Монголбанк, Засгийн газрын бодлогын дэмжлэг хэрэгтэй. Та бүхэн хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт байвал асууж болно.

Ц.Сүхбаатар:

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой 3 асуулт байна. Нэгдүгээрт Монгол банк “МИК Холдинг” ХК-ийн хувьцааны хэдэн хувийг эзэмшдэг вэ? Хоёрдугаарт “МИК Холдинг” ХК-ийн хувьцааны бүтцийг задаргаа юу вэ? Гуравдугаарт Монголбанкны 8 хувийн эх үүсвэрийг Засгийн газарт шилжүүлсэн тогтоол гарсан. Иймд дүрэм дахиад өөрчлөгдөх үү?

М.Мөнхбаатар:

Өнөөдрийн байдлаар Монголбанк 2 орчим хувийг хувьцаа эзэмшиж байна. Засгийн газрын шийдвэр гарсан. Гэхдээ олгогдсон байгаа 8 хувийн хөтөлбөрийн 90 орчим хувийг санхүүжилтийг Монголбанк хийсэн. Цаашид Олон улсын валютын сан, Засгийн газрын хооронд 8 хувийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэхээр яригдсан. Гэхдээ Монголбанк мөнгөний бодлогыг тодорхойлдог банкны системд хяналт тавьдаг байгууллага учраас тус банкны дэмжлэг бидэнд хэрэгтэй гэж ойлгож байна. Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд хамгийн том хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын

хөгжлийн банк 14 хувь, Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар хотын банк тус бүр 10 хувь, “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХ 7 хувь, Голомт банк 5 орчим хувийг тус тус эзэмшиж байна. Энэ бүх мэдээллийг Монголын хөрөнгийн биржийн сайт дээр тодорхой дэлгэрэнгүй байгаа тул танилцаж болно. Нэмж хэлэхэд 8 хувийн хөтөлбөр цаашид үргэлжилнэ гэж ойлгож байна. Сүүлийн 4 жил 8 хувийн хөтөлбөр анх хэрэгжиж эхэлсэнтэй харьцуулахад санхүүжилт бага байна. Ярианы эхэнд дурдсан 2019 оны 1 дүгээр сарын эхэнд та бүхний дэмжлэгтэй бонд гаргасан нь орон сууцны зах зээлийг тэлэх, мөн МИК гэдэг компани зөвхөн нэг чиглэлийн үйл ажиллагаа давамгайлж байсан бол 20 орчим хувь нь бонд гаргасантай холбоотой, үлдсэн 80 гаруй хувь нь 8 хувийн эх үүсвэр болон бусад эх үүсвэртэй холбоотойгоор өөрчлөгдсөн. Хөндлөнгийн аудит хийж дууссаны дараа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгнө. Хувьцаа эзэмшигчдээс өөр асуулт байна уу? Байхгүй бол саналын хуудсыг тараасан та бүрэн саналаа 20 минутад багтаан өгнө. Тооллогын комисс хэлэлцсэн асуудалтай холбоотой санал хураалтын дүнг танилцуулна уу?

С.Амарсайхан: Санал хураалтын дүнг танилцуулъя. Өнөөдрийн Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “...3 нь хараат бус...” гэсний дараа “..., 1 нь Монголбанкны төлөөлөл бүхий ердийн...” гэж нэмэлт, өөрчлөлт оруулах асуудалд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 12,047,883 хувьцаа эзэмшигч зөвшөөрсөн буюу 96.62 хувь, татгалзсан хувьцаа эзэмшигч байхгүй, түдгэлзсэн 421,249 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 3.38 хувь байна.

М.Мөнхбаатар: Баярлалаа. Санал хураалтын дүн танилцуулсан учраас дараах хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол батлагдлаа. Тогтоолыг уншиж танилцуулъя. 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр, Улаанбаатар хот Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн тогтоох нь: 1. Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “...3 нь хараат бус...” гэсний дараа “..., 1 нь Монголбанкны төлөөлөл бүхий ердийн...” гэж нэмэлт, өөрчлөлт оруулсугай. 2. Энэ тогтоолын 1-т заасан дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж хянуулах, улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай. 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (М.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай. Та бүхэнд хуралд идэвхтэй оролцсонд талархлаа. Ажлын амжилт хүсье.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:



Г.Саруул
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

М.Мөнхбаатар
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурлын дарга